



Чүлтэмийн ДУГАРЖАВ

ТАНИЛЦУУЛГА

Монголын ШУА-ийн академич, Оросын ШУА-ийн гадаад гишүүн, шинжлэх ухааны доктор, профессор Ч. Дугаржав нь 1970 оноос МОХБИБ экспедицийн Ойн хайгуул анги, 1975-1980 онд Завхан аймгийн Тосонцэнгэлийн Ойн суурин, 1980- 1990 онд Төв аймгийн Мөнгөнморьтын ойн сууринд, 1991-2015 онд Булган аймгийн Хялганат дахь ойн суурингийн урт хугацааны мониторинг судалгааны бүрэлдэхүүнд оролцож Монгол орны ойн газарзүйн тархалт, хэвшинж, бүтэц бүрэлдэхүүний онцлог, зүй тогтолыг илрүүлэх, мод огтлолт, түймрийн дараах , байгалийн сэргэн ургалт, ой үржүүлэг, хүлэрт намаг зэрэг чиглэлээр судалгаа явуулсан болно. . 1980 онд “ Хангайн нурууны шинэсэн ойн байгалын нөхөн ургалт” сэдвээр ХАА ухааны доктор (Ph.D) зэрэг, 1995 онд “Монгол орны шинэсэн ой “ сэдвээр ХАА Шинжлэх ухааны докторын (SC.D) зэрэг хамгаалсан. Академич Ч. Дугаржав нь сүүлийн жилүүдэд Монгол орны ой, хүлэрт намгийн экологи, ой үржүүлэг, доройтсон ой ба намгийн экосистемийг нөхөн сэргээх шинэ дэвшилтэд технологи боловсруулах судалгаа туршилтын ажил гүйцэтгэж байна..

БҮТЭЭЛ (дэлгэрэнгүй)

Нэг сэдэвт бүтээл, ном-38

Гадаад хэл дээр-22

Монгол хэл дээр-16

Эрдэм шинжилгээний өгүүлэл-169

Гадаад-101

Дотоод-68

Эрдэм шинжилгээний илтгэл-110

Гадаад--38

Дотоод-72

Удирдсан болон гүйцэтгэсэн төсөл

Удирдсан төсөл-13

Гүйцэтгэсэн төсөл-30

ХОЛБОО БАРИХ

Утас: 976-99149072

Цахим шуудан: chultemdugarjav@gmail.com

БОЛОВСРОЛ

1964 – 1970 ОХУ, Санкт-Петербургийн Улсын Их Сургууль, Биологийн салбарыг Биологи-геоботаникч мэргэшилээр. Магистр

1975 – 1980 ОХУ-ын ШУАкадемийн В.Н. Сукачёвын нэрэмжит Ойн хүрээлэнгийн аспирантур, ХАА ухааны доктор (Ph.D)

1991 - 1995 ОХУ-ын ШУАкадемийн В.Н. Сукачёвын нэрэмжит Ойн хүрээлэнгийн докторантур, ХАА Шинжлэх ухааны доктор

АЖЛЫН ТУРШЛАГА

1970–2021 ШУА-ийн Ботаникийн хүрээлэн, Эрдэм шинжилгээний дэд, ахлах, тэргүүлэх ажилтан, эрдэмтэн нарийн бичгийн дарга, захирал

СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛ

- Ойн тархац, экологи, хэвшиинж судлал, байгалийн нөхөн ургалт, ой үржүүлэг, дендрохронолог, хүлэрт намаг судлал.

ШАГНАЛ

2001 "Алтан гадас" одон

Ардын хувьсгалын 60, 70, 80, 90 жилийн ойн медаль

1996 ОХУ-ын Газарзүйн нийгэмлэгийн диплом

2004 ОХУ-ын Санкт-Петербург хот байгуулагдсаны 300 жилийн ойн медаль

1998 НУБ-ын байгаль орчны талаарх Сасакавагийн нэрэмжит шагнал

1995 БОЯ-ны "Байгаль орчныг хамгаалахын тэргүүний ажилтан"

2010 “Шинжлэх ухааны тэргүүний ажилтан”

2005 “Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрийн тэргүүний ажилтан

2006 ШУА-ийн оны шилдэг бүтээлийн шагнал

2006 “Алтан медаль”

1993 ШУА-ийн шилдэг өгүүллийн шагнал

-ШУА-ийн хүндэт жуух бичиг (1980, 1991, 2004)

2015 Ой модны салбарын 90 жилийн ойн медаль

2022 Шинжлэх Ухааны Гавьяат зүтгэлтэн